

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.08.21 № 433

танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад
нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцохор ирүүлсэн бие даан нэр дэвшигч Бямбадоржийн Эрдэнэбаатарын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын 2024 оны сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Орон нутгийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Бямбадоржийн Эрдэнэбаатарын /РД:ИЭ60122512/ Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Б.Эрдэнэбаатарын мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Б.Эрдэнэбаатарт



**Улиастай сумын бодлын гол багийн иргэн
Бямбадоржийн Эрдэнэбаатар миний 2024 оны Орон нутгийн сонгуульд бие даан нэр
дэвших мөрийн хөтөлбөр**

2024-07-18

Улиастай сум

Аливаа улс, аймаг, сумын орон нутгийн хөгжил нь Төрийн байгууллагын бодлогын хүрээнд тухайн орон нутгийнхаа алс хэтийн хөгжлийн чиг хандлагыг зөв тодорхойлсон, нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан түүнийгээ урт хугацаанд хэрэгжүүлэх, мөн тогтмол хэрэгжилтэнд хяналт тавьж, шинэчилэн боловсоруулагдан хэрэгжүүлж, мөрдөж ажилласанаар хөгжлийн үйл явц тодорхойлогддог.

Сүүлийн жилүүдийн манай аймаг, сумын хөгжлийн явц нь 4 жилээр ялсан намын явцуу бодлогын хүрээнд төсөөлөгдөж төлөвлөгдөн хийгдэж байгаа нь Завхан аймаг, Улиастай сумын алс хэтийн хөгжлийн явцыг алдагдуулах төлөвтэй байгаа тул Монгол Улсын ууган түүхэн Завхан аймаг, Эртний түүхэн Улиастай хот, нийт сум орон нутгийнхаа хөгжлийн гарцыг шинэ цагийн Ардчилсан нийгэм, Зах зээлийн эдийн засгийн харилцаанд тулгуурлан, Шинжлэх ухаан, техник технологийн дэвшил, орон нутгийн онцлог, түүхий эд материалын нөөц боломж, мэргэжилтэй ажиллах хүчин, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл байдал, тэдний санал хүсэлтэнд тулгуурлан зөв тодорхойлон төлөвлөн ажиллах үүднээс энэ хүү мөрийн хөтөлбөрөө боловсруулсан болно.

Нэг: Завхан аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн чиг хандлагын хүрээнд

1.Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын засгийн газраас дэвшүүлэн хэрэгжүүлж байгаа “Алсын хараа 2050”, “Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр”, “Хөдөөгийн сэргэлт”, “Хүнсний хувьсгал”, “Шинэ сэргэлтын бодлого” зэрэг ойрын болон алс хэтийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр, зорилтуудыг удирдлага болгон, Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хуулийн хүрээнд, Завхан аймгийн үе үеийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг Даргын Тамгын Газраас дэвшүүлэн хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засгийн хөгжлийн олон хөтөлбөр, зорилтуудыг нэгтгэн судлаж, цаашид улам боловсронгуй болгон шинэ шинэчилсэн хөтөлбөр зорилтыг боловсруулан тууштай хэрэгжүүлж мөрдөж ажиллах нөхцөлийг хангахад санаачлага гарган ажиллана.

2.Аймаг, орон нутгийн хөгжлийн онцлог шинж чанар, иргэдийн аж амьдрал, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч Аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, үйлдвэрлэлийн түүхий эд бүтээгдэхүүний нөөц боломж, хэрэглээнд тулгуурласан, байгаль цаг уурын нөхцөл, шинэ цагийн зах зээлийн эдийн засгийн харилцаа, шинжлэх ухаан, техник технологийн дэвшилд сууриалсан, шинэ хөгжлийн хөтөлбөр, бодлого төлөвлөлтийг “1-5 жил ойрын, 5-10 жил дунд хугацааны, 10-20 жил алс хэтийн” гэхчлэн Завхан аймаг, Улиастай хот, сумдыг эрчимтэй хөгжүүлэх “Завхан аймгийн хөгжлийн гарц-20” шинэ хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллахад санаачлага дэвшүүлэн ажиллана.

3.“Завхан аймгийн хөгжлийн гарц-20” шинэ хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллахад Аймаг, сумын Иргэдийн хурал, Засаг даргын тамгын газар, Хэлтэс тасаг, агентлагууд, Улс төрийн намууд, Олон нийтийн байгууллагууд, Мэргэжлийн холбоод, Нутгийн зөвлөлүүд, Эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, нутгийн эрдэмтэн судлаачид, нийт иргэд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч Аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоонд тулгуурлан боловсруулсан нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрөө аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн хууль эрх зүйн хүрээнд баталгаажуулаж, цаашид туштай боловсоронгуй болгон хэрэгжилтиг хангуулах арга хэмжээг авч ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд санаачлага гарган ажиллах Цаашидын аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чанар, чадамжыг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

Хоёр: Үндэсний үйлдвэрлэл үйлчилгээ, хот төлөвлөлт хөгжлийн хүрээнд

4. Аймаг, орон нутгийн хөгжлийн онцлог шинж чанар, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч Аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, үйлдвэрлэлийн түүхий эд бүтээгдэхүүний нөөц боломж, хэрэглээнд тулгуурласан, байгаль цаг уурын нөхцөл, зах зээлийн эдийн засгийн харилцаа, шинжлэх ухаан, техник технологийн дэвшилд суурисан үндэсний үйлдвэрлэл үйлчилгээний салбарын хөгжлийг сайжруулж, эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэн, иргэдийн аж амьдрал, амжиргааны түвшинг дээшлүүлэх, ажил хөдөлмөр тогтвортой эрхлэх нөхцлийг сайжруулахад санаачлагатай ажиллана.

5. Уламжлалт МАА-н үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэн, мал эмнэлэгийн үйлчилгээ, малын үйлдэр угсаа, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, байгаль цаг уурын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсоронгуй болгон, эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжиж ажиллах мөн газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжлийн хөтөлбөрийг төр, хувийн хэвшилийн хамтын ажиллагаа бодлогын хүрээнд боловсруулж орон нутгийн хүнсний ногоо, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэхэд санаачлагтай ажиллана.

6. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Газрын харилцааны багц хуулийн хүрээнд аймаг сумын төвлөрсөн суурин газрын хот төлөвлөлт хөгжлийн явц, газар зохион байгуулалтын ажил, түүний хэрэгжилтийг хуулийн хүрээнд улам боловсоронгуй болгон хэрэгжилтийг ханган ажиллахад онцгойлон анхаарч санаачлагтай ажиллана

Гурав: Төр, олон нийт, ААНэгж байгууллагууд, хамтын ажиллагааны хүрээнд

7. Төрийн захиргаа болоод төрийн үйлчилгээний байгууллагын ажиллагсадын ажиллах нөхцөл, ажлын хариуцлага, мэдлэг чадвар, сахилга зохион байгуулалт, идэвхи санаачлагыг сайжруулж иргэд Аж Ахуйн нэгж байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмж, хөнгөн шуурхай чирэгдэлгүй байх нөхцлийг бүрдүүлэн ажиллахад санаачлага гарган ажиллана.

8. Аймаг сумын хөгжлийн чиг хандлагыг зөв тодорхойлон төлөвлөж, цаашид хэрэгжилтийг хангуулхад Аймаг, сумын төрийн байгууллага, олон нийт, Иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн хамтын ажиллагаа, оролцоо идэвхи санаачлагыг сайжруулах үүднээс аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг Даргын Тамгын газрын хийж хэрэгжүүлж байгаа ажил, гаргасан шийдвэр, түүний хэрэгжилтийн талаар олон нийтэд нээлтэй мэдээлэлээр хангах нехцлийг сайжруулж, сум багийн Иргэдийн Нийтийн хурлын үйл ажиллагааг тогтмолжуулж иргэд, олон нийтийн оролцоо идэвхи санаачлагыг нэмэгдүүлэхэд санаачлага гарган ажиллана.

9. Төрийн байгууллагын бодлогын хүрээнд боловсруулсан нийгэм эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь Олон нийт, Иргэний нийгмийн байгууллагууд, Салбарын мэргэжлийн холбоод, Ажил олгогч үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч Төр, хувийн хэвшлийн Аж Ахуйн нэгж байгуулага, иргэн бөгөөд тэдний оролцоо идэвхи санаачлага, мэргэжилийн ур чадвар, ажлын чанар, үр ашигийг улам нэмэгдүүлэх үүднээс төрөлжсөн уулзалт хэлэлцүүлэг, сургалтын үйл ажиллагааг сайжруулан чанар хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллахад санаачлага гарган ажиллана.

ATA6355 0009370
07/01/2019 10:09

Мөрийн хөтөлбөр боловсруулж хүргүүлсэн
Улиастай сумын Богдын гол багийн иргэн



Б.Эрдэнэбаатар